

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
2022 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудитын нэр.....	3
2. Аудитын код.....	3
3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
4. Аудитын зорилт	3
5. Аудитын хамрах хүрээ.....	3
6. Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын явцын ерөнхий мэдээлэл.....	4
7. Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ	5
8. Аудитын арга зүй.....	5
9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	6
10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	6
11. Аудитын хугацаа	6
12. Аудитын хөтөлбөр	7
13. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:	7
14. Аудитад шаардагдах санхүү болон хүний нөөц.....	7

ХАВСРАЛТУУД:

1. Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ
2. Асуудлын шинжилгээ
3. Аудитын загварын матриц
4. Аудитын хөтөлбөр
5. Үр өгөөжийн тооцоолол
6. Шинжээчийн ажлын даалгавар
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт
8. Эрх шилжсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ЗАНДАНБАТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

2. Аудитын код

АГГ-2022/16-ШТА-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны "Аудитын сэдэв батлах тухай" 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийнэ.

4. Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт үр дүнтэй хийгдсэн эсэх.

5. Аудитын хамрах хүрээ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 1,101 төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн аудитыг хийнэ.

Тус аудитаар 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн 24 Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа байгууллагууд, Сангийн яам, Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулна.

20

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудит гүйцэтгэж, Аудитын гуравдугаар газар үр дүнг нэгтгэн, нэгдсэн тайланг бэлтгэнэ.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн 849.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 266.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх 5 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд “Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “арих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт”-ийг тусгайлан сэдэвт аудит болгон гүйцэтгэх тул энэхүү аудитад хамрахгүй.

6. Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын явцын ерөнхий мэдээлэл

Улсын Их Хурлаар 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 24 ТЕЗ-ийн төсвийн багцад 3,763.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,100 төсөл, арга хэмжээнд 1,390.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн оруулсан өөрчлөлтөөр шинээр эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 110.0 тэрбум төгрөгөөр, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 8.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 22 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 90.0 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

Төсөвт хийсэн тодотголоор 2021 онд өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 643, шинээр 458, нийт 3,881.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,101 төсөл, арга хэмжээг 1,418.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт санхүүжилтийн 76.5 хувийг 789 барилга, байгууламж, 14.2 хувийг 119 тоног төхөөрөмж, 6.0 хувийг 166 их засвар, 3.3 хувийг 27 техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах төсөл арга хэмжээнд тус тус зарцуулахаар байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг салбараар нь ангилж үзвэл нийгмийн салбарт 49.3, дэд бүтцийн салбарт 34.4, бусад салбарт 11.9, хууль сахиулах, батлан хамгаалах салбарт 4.4 хувийг зарцуулахаар тус тус хуваарилсан байна.

Батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 1,311.4 тэрбум төгрөгийг олгож, 92.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 87.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 211 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын шийдвэр болон Төсвийн ерөнхийлөн захирагчдын шийдвэрээр орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.14, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.3-т заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдлийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Үндэсний аудитын газраас өмнөх онд “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Сангийн сайдад 3, ТЕЗ нарт 4, нийт 11 зөвлөмж, 6 Төсвийн ерөнхийлөн захирагчийн

2,866.3 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт, 8 төсвийн ерөнхийлөн захирагчийн 84,971.3 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлснээс төлбөрийн акт, албан шаардлагаар улсын төсөвт 4,297.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 62,042.2 сая төгрөгийн 3 албан шаардлага хугацаандаа хэрэгжсэн. Энэ аудитаар өмнөх аудитаар өгсөн хугацаандаа хэрэгжээгүй зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хамруулан авч үзнэ.

7. Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ

Аудитын урьдчилсан судалгааны ажлын явцад орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагуудаас ирүүлсэн санал, Төсвийн ерөнхийлөн захирагч нараас авсан судалгаа, цуглуулсан баримт материалд хийсэн дүн шинжилгээ, аудитын багийн гишүүдийн саналд үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. *(Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээг хавсралт 1-д үзүүлэв)*

8. Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. *(Аудитын асуудлын шинжилгээг Хавсралт 2, Аудитын матрицыг Хавсралт 3-аар бэлтгэв)*

Аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх бөгөөд төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй нь аудитын бүх үе шатны туршид үргэлжлэх үйл ажиллагааг хамрах тул аудитын явцад томоохон өөрчлөлт гарсан, гүйцэтгэл, тайлагналын үе шатанд нэмэлт горим хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд энэхүү төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудит хийж, тайланг баталгаажуулж, холбогдох судалгаа, зөрчлийн жагсаалтын хамт Үндэсний аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ. Орон нутаг дахь Төрийн аудитын газрууд нэгдсэн төлөвлөгөөнд үндэслэн орон нутгийн онцлогт тохируулж, дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг баталж болно.

Мөн орон нутаг дахь Төрийн аудитын газрууд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад аудит хийх төлөвлөгөө, хөтөлбөрийг нэгтгэх боломжтой байдлаар нэгдсэн стандартаар боловсруулж, заавар чиглэлээр хангах ажлыг Нийслэл дэх Төрийн аудитын газар удирдан чиглүүлж, аудитын тайлан, холбогдох судалгааг Үндэсний аудитын газарт дээрх хугацаанд ирүүлнэ.

Аудитын урьдчилсан судалгааны ажлын үр дүнгээр аудитад хөндлөнгийн шинжээч авах хэрэгцээ, шаардлагатай гэж тодорхойлсон тул орон нутаг дахь Төрийн аудитын газруудаас ирүүлсэн санал, зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан Үндэсний аудитын газрын 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу зарим барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөг, магадлал хийсэн байдал, гүйцэтгэлийг нарийвчлан шалгах зорилгоор аудитад хөндлөнгийн шинжээчийг татан оролцуулна. Сонирхлын зөрчилгүй хуулийн этгээд, иргэнийг сонгон шалгаруулах ажлыг Үндэсний аудитын газрын Захиргаа, удирдлагын газар зохион

байгуулж, гэрээний үүргийн хэрэгжилт, үр дүнд Аудитын гуравдугаар газрын болон орон нутаг дахь Төрийн аудитын газрын аудитын баг хамтран хяналт тавина.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон улсын төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Тухайн аудитын зорилтыг хангахад чиглэсэн аудитын асуудлын шинжилгээнд тусгагдсан асуултууд (*Хавсралт 2*);
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, аудитын менежер Б.Саруул аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батдэлгэр, аудитор Ж.Оюунтуяа, Ш.Наранбаатар, С.Одонцэцэг, Г.Оргилмаа, шинжээч Б.Мөнхцэцэг, гэрээт ажилтан И.Дөлгөөнтуул нар болон орон нутаг дахь Төрийн аудитын газрын аудиторууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

Аудитын явцад эрх бүхий этгээдийн шийдвэрээр багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

Аудитын төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, нэгдсэн тайланг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2021 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулж, баталгаажуулан 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор УИХ-ын Төсвийн байнгын хороо болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

12. Аудитын хөтөлбөр

Аудитад хамрагдах Төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр талбарт гүйцэтгэх ажлыг асуудлын шинжилгээний хүрээнд тайлагналын үе шатанд нэгтгэл хийх ажлыг аудитор бүрээр хуваарилж аудитын хөтөлбөрт тусгав. Аудитын багийн гишүүд талбарын ажлыг гүйцэтгэх нарийвчилсан дэд төлөвлөгөө боловсруулж, газрын захирлаар батлуулан, хугацаа чанарын шаардлагыг мөрдөж ажиллана. *(Хөтөлбөрийг хавсралт 4-өөр харуулав.)*

13. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгадагч этгээдэд танилцуулахаас гадна хамаарал бүхий хэсэгтэй бусад шалгадагч байгууллагад танилцах боломжийг олгоно. Шалгадагч этгээдээс санал авч, нэгдсэн тайлангийн эцсийн хувилбарыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.